



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/347

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Цамхагийн холбоо, ажиглалтын системийн сэлбэг нийлүүлэх ИНУТ/УЗ/НТШ/Б-96/21 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Цогоо

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн дарга

Гишүүд:

Д.Доржмягмар

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн  
Радиолокаторын техник ашиглалт,  
автоматжуулалтын тасгийн ахлах инженер

Э.Энхжин

Худалдан авах ажиллагааны тасгийн  
хангамжийн мэргэжилтэн

С.Энхжаргал

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Санхүү,  
хангамжийн хэсгийн нягтлан бодогч

Ю.Оюунтуяа

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Санхүү,  
хангамжийн хэсгийн нярав

2. Дээрх барааг гэрээнд заасан тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг Ажил хүлээж авах комисс (Б.Цогоо)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ